



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар A/121

Хажуу шинэ үс

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21.4.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Угтаал сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр (Дэлгэр хонгор 1 гудамжны 104)-т байршилтай 69 м.кв газрыг Лхамсүрэнгийн Сайхантуяа (ЗВ71060902)-д гэр, орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д үүрэг болгосугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө хугацаанд нь төлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ДОРЖСҮМБЭР

482401128